



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Ажлын хэсэг шинэчлэн
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11, Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Ерөнхий гэрээ байгуулах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий гэрээгээр худалдан авах урвалж, оношлуур, хэрэгслийн жагсаалтыг боловсруулан, Мэргэжлийн байгууллагад саналыг хүргүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Ерөнхий гэрээгээр худалдан авах урвалж, оношлуур, хэрэгслийн жагсаалтыг боловсруулах үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Г.Цэцэнсанаа)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/158 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ЗЭНДМАА



1423 010103

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20~~23~~²⁴ оны ~~05~~⁰⁶ дугаар сарын ~~31~~⁰¹ -ны
өдрийн ~~8/~~¹⁰⁵ дугаар тушаалын хавсралт



Ерөнхий гэрээгээр худалдан авах урвалж, оношлуур, ~~хэрэгслийн жагсаалтыг~~
боловсруулан, Мэргэжлийн байгууллагад саналыг хүргүүлэх ажлын хэсгийн
бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын Эм хангамжийн газрын дарга

Гишүүд:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын Эмийн бүртгэлийн хэлтсийн Эмийн бүртгэлийн
зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гэрээт зөвлөх,
Эрүүл мэндийн яамны лабораторийн салбар
зөвлөлийн гишүүн /зөвшилцсөнөөр/

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нэгдсэн
лабораторийн албаны дарга, Эрүүл мэндийн яамны
лабораторийн салбар зөвлөлийн гишүүн
/зөвшилцсөнөөр/

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эмнэлзүйн эмгэг
судлалын нэгдсэн лабораторын дарга
/зөвшилцсөнөөр/

Монолаб ХХК-ний Гүйцэтгэх захирал /ханган
нийлүүлэх байгууллагуудын саналаар/

Сүвэн-Уул ХХК-ний Эм, эмнэлгийн хэрэгслийн албаны
дарга /ханган нийлүүлэх байгууллагуудын саналаар/

Нарийн бичгийн дарга:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын Эм хангамжийн газрын Эм, эмнэлгийн
хэрэгслийн худалдан авах ажиллагааны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын Эм хангамжийн газрын Вакцин,
биобэлдмэлийн хангамж, хүртээмж, ложистикийн
асуудал хариуцсан мэргэжилтэн